

**МЯНГАД ЭРДЭМТИЙН ЗАЯ БАНДИДА НАМХАЙЖАМЦ СУДЛАЛД
ОРУУЛСАН БҮТЭЭЛИЙН НЬ ҮНЭ ЦЭНЭ**

Б. Хишигсүх*

Зая бандида Намхайжамцын намтар, бүтээлийн судалгаа дотоод, гадаадын монгол судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсаар олон оныг үдсэн билээ. Эрдэмтэн, судлаач Мянгад Эрдэмтү Зая бандида Намхайжамц судлалын асуудалд ихээхэн нухацтай хандаж ганц сэдэвт бүтээл туурвисан байна. “Равжамба Зая бандида Намхайжамц судлал” /BIBLIOTHECA ORATICA VII., Равжамба Зая бандида Намхайжамц судлал.,УБ.2008/ хэмээх түүний бүтээл долоон бүлэг, арвандолоон зүйл, гуч гаруй хуудас бүхий хавсралт, ном зүй зэргээс бүрдсэн нийт 23.2 хэвлэлийн хуудас бүтээл түүх соёл, хэл бичиг судлалын цуврал /VII/-д хэвлэгдсэн.

Зая бандида Намхайжамцын судлалд ихэвчилэн түүний намтар болох Раднаабадрагийн “Равжамба Зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршибай” бүтээлээр дамжин орж ирдэг нь дотоод, гадаадын судлаачдын санал нэгдсэн болохыг баталж байна.

“Равжамба Зая бандида Намхайжамц судлал” бүтээлийн удиртгал нь:

1. БНХАУ дахь судалгаа
2. Монгол Улс болон бусад улс дахь судалгаа
3. Сурвалж хэрэглэгдэхүүн гэсэн гурван хэсэгтэй байна

Энд Зая бандида Намхайжамцын намтар, бүтээлийн судалгааны ажил Монгол Улсад, мөн БНХАУ-ын монгол судлалын чиглэлд хэрхэн яаж? судлагдсан ба гол гол судлаачдын бүтээлийг нэлээд дэлгэрэнгүй дурдсан байна. Тухайлбал, Эрдэмтэн судлаач Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Х.Лувсанбалдан, Ч.Далай, Н.Ишжамц, А.Очир, Ж.Цолоо, П.Хорлоо, Д.Цэрэнсодном, Д.Дагвадорж, Б.Катуу, Л.Алтанзаяа, На.Сүхбаатар нарын судалгааны өгүүлэл, бүтээлүүдийг мөн Орос /хуучнаар ЗХУ/-ын А.Попов, А.Бобровников, К.Ф.Голстунский, А.Г.Сазыкин, А.Б.Бадмаев, Ш.Б.Чимиддоржиев, Г.С.Лыткин, И.Я.Златкин болон Мажарын эрдэмтэн Диорд Кара, Японы Вакамази, Английн Жон Бадделэй, АНУ-ын Стивен, Хуркевк БНХАУ-ын эрдэмтэд Ма Ру Хан, Ма Да Жин, Лиү Жин Сүве, Ч.Хишигтогтох, Ши.Норов, Фан Си Ши, Цен Зун Де, Цай Жа Ян, Х.Жамц, Н.Басан, Эрдэнэбаяр, Н.Алтаншаа, Д.Галдан, Ли Баон, П.Дамбийпэлжид, С.Араа, Бу.Батмөнх, Басжингуа, Н.Хурцбилэг, Боржигдай Оюунбилэг, Г.Лижээ, Пү.Бадмаараг, И.Баяндалай нарын голлох өгүүлэл, бүтээлүүдийг дурдаж өгсөн явдал нь практик ач холбогдолтой зүйл болсон юм. Гол сурвалж хэрэглэгдэхүүн нь Санкт-

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Петербургийн Улсын Их сургуулийн номын санд хадгалагдаж буй 1860 онд Ижилийн Халимагийн Хошууд ноён Цэрэнжав Түмэний дуртгалаар гэлэн Шарманжиевийн сийрүүлсэн алтан бичмэл эх, ОХУ-ын ШУА-ийн Азийн угсаатныг судлах газрын номын сан дахь Позднеевийн цуглуулгад хадгалж буй эх, мөн тус газрын Санкт-Петербург дахь салбарт хадгалж буй 1910 онд Монгол Улсын Ховдын хязгаарын Баядын Нацаг бэйсээс Бурдуковын авч явсан эх, дээрхи газрын архивт хадгалагдаж бүхий 1936 онд Румянцевын эмхэтгэсэн бичмэл зэрэг дөрвөн бичмэл эх.

Монгол Улсад хадгалагдаж буй Халхын Зая бандидад Лувсанпринлэйн номын санд байсан одоо болтол мэдэгдээд байгаа цорын ганц тод үсгээс буулгасан уйгаржин монгол эх, 1963 онд Ховд аймгийн Манхан сумын Ванчиг, Түвдэн нар Монгол Улсын ШУА-д бэлэглэсэн тод эх зэрэг хоёр зүйлийн бичмэл буй.

БНХАУ-ын Шинжаан Уйгурын Өөртөө Засах орны Илийн Тэхэс сианы Нармайн Бадамын гарт нэг тод бичмэл эх байсныг судлаач Ши.Норов мэдээлсэн хэдий ч судалгааны эргэлтэд ороогүйг тэмдэглэсэн байна. Жич, Бээжин дэхь Улсын номын сан, Төвийн Үндэсний Их Сургуулийн номын сан, Бээжингийн Их Сургуулийн номын сан, Хааны ордны номын сан, Өвөр Монголын Их Сургуулийн номын сан, Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн номын сан, Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн номын сан, Өвөр Монголын Өөртөө Засах орны номын сан, Данс эвхмэлийн газар, Чэндэ хотын хааны зуслан дахь Тод үсгийн хөшөө чулуу, Алашаа зүүн хошуу болон Эзэнээ хошууны номын сан, Шинжааны Үрэмчи хотын номын сан, гэр музей зэрэгт байх бүхий л өвийг үзэж, судалж мэдээлсэн нь их чухал байна. Энэ нь дараа дараачийн Намхайжамц судлалын асуудалд шинэ тутам судлаачдад ихээхэн чухал мэдээлэл болсон байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Зая бандидын гэр бүл, түүний сахил авсан, Төвдөд очсон хийгээд Ойрадаа буцсан нь

Эдүгээг хүртэл Зая бандид Намхайжамцын намтар, бүтээлийн судлалд Раднаабадраагийн “Равжамба Заян бандидын тууж Сарын \сарны\ гэрэл хэмээх оршибай” хэмээх гар бичмэлийг эс тооцвол нэлээд бүрхэг байна. Зохиогч “Сарны гэрэл” болоод “V Далай ламын намтар”, “Алтан эрхи” \Хөх хот.1991\ зэрэг сурвалжийг харгуулан үзэж түүнийхээ үндсэн дээр Намхайжамцын 1599-1638 оныг хүртэл нийт 40 орчим жилийн түүхэн дэхь хамгийн чухал, сонирхолтой асуудал болох Төвдөд шавилж сурч, суралцсан 22 жил, мөн Ойрадад буцах болсон шалтгаан зэргийг нэлээд ул үндэстэй баримт дээр тулгуурлан гаргаж тавьсан нь Зая бандимд судлалд бас нэгэн шинэ алхам болж чадсан байна. Мөн Намхайжамцын угсаа гарал, дээд өвөг хийгээд ямар шалтгаанаар, хэрхэн тойн болсон явдлыг тодруулж өгчээ. Гол судлагдахуун нь “Ойрад түүхэн сурвалж”, “Таван барс” \тод үсгийн сурвалж бичиг\, “Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд” \III дэвтэр.УБ.2002., хэвлэлд бэлтгэсэн На. Сүхбаатар\, “Мин Улсын магад хууль”, “Мин Улсын түүх”\хятад сурвалж\, гаван шаравын “Дөрвөн Ойрадын түүх”, “Ойрад түүхийн дурсгалууд”\Үрэмчи. 1992\,

Дээрхэд нэг эргэлзээтэй асуудал байгаа нь Зая бандид Намхайжамцыг V Далай лам болоод IV Ванчин Эрдэнийн шууд оролцоотойгоор \даалгавартайгаар\ тэдний төлөөний хүн болж Ойрадад буцаж ирсэн тухайд “... Өөрийнхөө төлөөнд монгол газар явуулахад заавал хамгийн авхаалжтай мөртлөө өөрийнх нь үг номоор явдаг, өөрийнх нь зааврыг ёсчлон биелүүлдэг тийм хүнийг хайх хэрэгтэй. Төвдийн талд авч хэлвэл Зая бандида

бол хамгийн тохиромжтой хүн байжээ.”¹ гэсэн нь уг асуудалд арай л яаран дүгнэлт өгсөн мэт санагдана. Юутай ч Зая бандид Намхайжамц Төвдийн төлөөний хүн болж Ойрад нутагтаа буцаж ирсэн гэдэг нь ихээхэн эргэлзээтэй байна. Учир нь Зая бандид Намхайжамцыг Төвдөд шавилан суралцсан 22 жилийн хугацаа, мөн VДалай лам, IV Ванчин эрдэнэ нартай ойр дотно харьцаатай байсны улмаас тэдний төлөөний хүн болж улмаар тэдний үүрэг даалгавраар Ойрадад харьж ирсэн гэдэг нь тийм ч тулхтай зүйл биш болов уу.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Зая бандидын шашин дэлгэрүүлсэн үйлс болон дөрвөн Ойрадын дотоод зөрчлийг эвсүүлсэн чармайлт (1639-1642)

Энэхүү бүлэгт Зая бандид Дөрвөн Ойрадад төдийгүй, Ижил мөрний торгууд нарын дунд Хөх нуурын Хошуудад, долоон хошуу халхын нутагт Төвдийн шашныг дэлгэрүүлсэн асуудлыг их дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

Зая бандид Намхайжамцын Дөрвөн Ойрадад Төвдийн шашныг дэлгэрүүлсэн талаар дотоод, гадаадын монголч эрдэмтдийн дунд харьцангуй их судлагдсан байдаг билээ. Зая бандид Намхайжамц 1639-1662 оны хооронд нийтдээ 26 газраар аялж /Харбагай, Аблайн нутаг, Булнайн Усан хужирт, Төмөр цорго, Очирт тайжийн өвөлжөө, Дөрвөд Далай тайшийн хөвгүүн Дайчин хошуучийн суваргыг амилуулсан газар, Хаслугийн өвөлжөө, Мани Гамбум судар дахь Дархан цоржийн тэмдэглэл, Улаан өвх, Очирт тайжийн өргөө, Ижилийн торгууд дахь Шар тохой, Или голын адаг Илид нийлдэг Хүрд гол, Тод үсгээ зохиосон гэдэг Хас нуурын цутгалан Чүй гол, Байбагас хааны хатан Очирт тайжийн төрсөн эх Гүнж хатныг насан эцэслэхэд үйлдсэн буян номын үйл хэрэг, Илийн хөндий одоогийн Шинжааны Борталын Сайрам нуураас холгүй Талхи хэмээх газар, Тарвагатайн Улаан бураа, Үр ерийн Олухан, Хар буд, Таргун Эрдэнэ хунтайж нарын заллагаар Илийн газарт, Казахстаны хил дэхь Хөхүүрэгийн хоолой, Балхаш нуурт цутгадаг Хар тал, Эрдэнэбаатар хунтайжийн Буруд хатнаас төрсөн Цэцэн тайж тэргүүтнийг заллагаар, Булнайн Усан хужирт, Шинжааны Борталын Сайрам нуурын зүүн хөвөөн дэхь Нуурын хорголжин, Отог монцог, Шар тохой, Хар бут, Дундад Ташигай гэх зэрэг газарт/ шашин түгээх дэлгэрүүлэх, буян номын ажил үйлс цогцлоох, сан тавих, суварга аравнайлах, өргөл өргөх зэрэг буяны ажлуудыг хийж явсныг баримтаар баталгаажуулсан байна.

Зая бандид Халх долоон хошуунд шашин дэлгэрүүлсэн нь (1641-1642)

Зая бандид Намхайжамцыг Засагт хан /Субадай, Далай ламаас Засагт хан цол хүртсэн. Халх, Ойрадын олон жилийн цус асгаруулсан дайныг зогсоож харийн түрэмгийлэгчдийг хамтаар эсэргүүцэх чухал үйлийг санаачилсан болон/, Түшээт хан /Түшээт хан Гомбодорж, /, Цэцэн хан /Махасамади хэмээн өргөмжлөгдсөн/ нар Халхад залж буян номын үйлийг бүтээжээ. Эндээс Зая бандид “Их цааз”-ыг ухуулах, таниулах зорилгоор гэхээсээ илүү Халх, Ойрадын их эв нэгдэл улмаар Монголчуудын хүчирхэг байх үеийн тэр их түүхийг сэргээж, сэнхрүүлэх алс хэтийн зорилготой байсан болов уу, мэт санагдана.

Зая бандид Төвд-Ойрадын зөрчлийг эвсүүлсэн нь хэсэгт:

¹ Равжамба Зая бандид Намхайжамц судлал, УБ., 2008, 49-р тал.

- Ухарлигийн дайныг эвсүүлсэн нь
- Цагчахай арлын дайныг зогсоосон нь
- Мангудын оруулын булаалдааныг зогсоосон нь
- Очирт тайж, Авлай хоёрыг эвсүүлэхээр чармайсан нь зэрэгтээ Зая бандидын эвлэлдэн найрамдах төв үзлийг гаргаж тавьсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: Зая бандидын зохиосон тод үсэг

Энэхүү бүлэгт Зая бандид Намхайжамцын зохиосон тод үсгийн талаархи судалгаа болоод тод үсгийг зохиосон тухайд эрдэмтэд, судлаачдын дунд нийтдээ 5 янзын санал байдаг бөгөөд энэ нь, **нэгдүгээрт:** Баатар хунтайж Тод үсгийг дуртган зохиолгосон хэмээх үзэлт, **хоёрдугаарт:** Баатар хунтайж хийгээд Аблай тайж хоёулаа Тод үсгийг зохиосон хэмээх үзэлт, **гуравдугаарт:** Очирт цэцэн хан, Аблай тайж, Баатар хунтайж гурвуулаа Тод үсгийг дуртган зохиолгосон хэмээх үзэлт, **дөрөвдүгээрт:** V Далай лам Тод үсгийг дуртган зохиолгосон хэмээх үзэлт, **тавдугаарт:** Байбагас баатар Тод үсгийг дуртган зохиолгосон хэмээх үзэлт зэрэг болно.

Тэгвэл судлаач мянгад Эрдэмт Тод үсгийг үнэнхүү зохиолгогч нь Очирт тайж хийгээд Аблай тайж хоёр болно,² гэсэн нь бидний олон арван жил баримталж ирсэн 1648 онд Зая бандид Намхайжамц тод үсгийг зохиожээ, гэдэгтэй зөрчилдөж байгаа юм. Судлаач уг санаагаа батлахдаа Зая бандидын зохиосон “Үсгийн найрлага” хэмээх цагаан толгойн төгсгөл шүлгийг /89-91 талд/ задлан тайлбарлажээ. Тод үсгийн асуудлаар дотоод, гадаадын олон судлаачид үгээ хэлж, өөрсдийн судалгаа шинжилгээний бүтээл туурвилаа зориулсан учирт энэ тухай дэлгэрэнгүй ярихгүй байхаар шийдлээ.

Хошуудын Очирт тайж, Аблай тайж, Зая бандид Намхайжамц нарын харилцааны асуудалд “Дайчин Улсын магад хууль”, “Зүүнгар хаант Улсын түүх”, “Тавдугаар далай ламын намтар”, “Богд Чингисийн төрийг бариад хаан өргөө тэтгэсэн тууж” зэрэгт бичиж тэмдэглэснээс үүдээд Зая бандид Намхайжамц 1639-1661 оны хооронд нийтдээ 20 удаа Очирт тайж болоод Аблай тайжтай тодорхой тодорхой асуудлаар учран золгож, зөвшин хэлэлцэж их үйлийг хамтатгаж байсан нь нэгэнт тодорхой байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: Зая бандидын орчуулгын үйлс

Монголын орчуулгын уран зохиолын хөгжлийн түүхэнд Ойрадын Зая бандид Намхайжамцын орчуулгын үйлс хүндтэй байрыг эзэлдэг билээ. Судлаач Зая бандидын орчуулгыг,

- Түүх
- Хэл
- Уран зохиол
- Эм эмнэлэг

- Зурхай хэмээн ангилж үзсэн байна. Судлаач Зая бандидын орчуулгын зохиолын талаар хэдий хэр хэмжээтэй зүйл хадгалагдсаныг бүртгэсэн бүртгэл, мөн цаана нь бүртгэгдээгүй байгаа бүтээлүүд болоод шинэ бүртгэлийг гаргахдаа төгсгөлийн шүлгийн шад, бадгийн тоог нарийвчтлж гаргахыг зорьсон байна. “Барс

² Равжамба Зая бандид Намхайжамц судлал. УБ., 2008, 89-р тал.

жилээс барс жил” хэмээх үзэлтийн дор 1602 оны усан буюу хар барс жилээс 1662 оны усан буюу хар барс жилийн хугацаанд буюу 60 жилд усан буюу хар барс жил хоёронтоо тохиох уу? гэдэг асуудал ч бас гарч ирж байна. Зая бандидын орчуулгын бүтээлүүд гэвэл,

1. Ганжуурын хөлгөн судар болоод Зарлигийн тайлбар буюу “Данжуурын хөлгөн судар” /Зарлиг гэдэг нь Шонувдондувын номлосон зарлиг болно/
2. Банчин хутагтын тууж /1642/
3. Эцгийн ном хэмээх айлтгал хариу чандмань эрхин судар, төгсгөлийн шүлэг /1643/
4. Чойжид дагинын тууж
5. Мани Гамбум /1643-1644/
6. Хутагт Дарь эхийн магтаал судар, төгсгөлийн шүлэг /1638-1644/
7. Сайвар одсон шашныг тодотгон үйлдэхүй эрдэнэ сайн зарлигийн сар ном гарахуй хэмээхүй /1638-1644/
8. Бодисад унал мөргөл хэмээх судар /1638-1644/
9. Номын хаан Зонховын тууж сүсэгийн орлого хэмээх /1638-1655/
10. Мэдээтэй, мэдээ үгүйг ялгагч хэмээх судар /1638-1655/
11. Үлгэрийн далай /1638-1655/
12. Торгууд хаадын тууж/1645/
13. “Алтангэрэл”, “Дорж зодов” /1650/
14. “Сундуй”, “Банзрагч”, “Хутагт билигийн чанад хүрсэн зүрхэн оршибай”
15. Хутагт цаглашгүй настын бэлгэ билигт хэмээх их хөлгөний судар оршибай
16. Огторгуй газрын найман гэгээн хэмээх их хөлгөний судар
17. Хутагт өлзий давхарласан хэмээх их хөлгөний судар оршибай
18. Хутагт билгийн чанад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар оршибай
19. Хутагт их тонилсны зүгт дэлгэрүүлэгч их хөлгөний судар оршибай
20. Хутагт арван зүгийн харанхуй бүхнийг арилгагч их хөлгөний судар
21. Хутагт бодьсадын унал наманчлахын судар оршибай
22. Бурханы цагаан шүхэрт их судар оршибай
23. Хутагт хилэнц наманчлах алтан усны хутга там эвдэх хуурай
24. Үзсээр туст чухал хэрэгт оршибай
25. Нагаржунын зарлиг оршибай
26. Эрдэнийн сан Субашид
27. Эрдэнэ чойжид дагины тууж хэмээх судар
28. Эрдэнэ шастир оршибай
29. Хутагт хар ам хэл амаржуулан үйлдэгч судар оршибай
30. Базар бидиринэ
31. Найман мянгат оршибай
32. Тарни унших арга
33. Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увидасын үндсэнээс хэсэг дөрвөн хойд үндсэн хэмээх оршибай
34. Зуу Адишагийн увидас үндэслэсэн зүрхний үг
35. Бодь мөрийн үе хураасан
36. Сайн оюут Далай ламын магтаал
37. Унал наманчлах хэмээх цогт зандан оршибай

38. Таслагч очирын тайлбарын судар оршибай
39. Дорж зодовын ач тус оршибай
40. Лусуудын сан оршибай
41. Тус бүтээсэн хаан хөвгүүний тууж оршибай
42. Бисман тэнгэр лугаа адил баяжсан Зомчо хөвгүүний тууж оршибай
43. Бурханы цадиг их номын тууж оршибай
44. Хашин хааны шастир
45. Рашааны зүрхэн найман үет нууц увидасын үндэснээс хоёрдугаар хэсэг номлохуйн үндсэн хэмээх оршибай
46. Шашинд орохын үүдэн итгэлийн хөтөлбөрийн сэхээн сайн хувьтны эрэл хангагч хэмээх оршибай
47. Хутагт огторгуй газрын найман гэгээн
48. Гаслангуй номын хааны тууж өчүүхэн номлосон хийгээд бүхэнд дэлгэрсэн Цэцэг хааны хөвгүүний тууж оршибай
49. Зургаан бярман бүтэхүй ерөөл
50. Алтангэрэлийн хураангуй
51. Арван бурханы зарлиг
52. Цагаан өвгөний өгүүлсэн судар
53. Боди мөрийн зэргийн үе оршибай
54. Бодь мөр үндэслэсэн лам нарын залбирал оршибай
55. Ланрай Данбагийн найман шүлэгт оюун судлахуй оршибай
56. Э Иү Гвагийн үндсэн лам нарын залбирал оршибай
57. Дөт үндсэн лам нарын магтаал оршибай
58. Эрдмийн далай ламын магтаал
59. Инза ринбүчийн тууж магтаал оршибай
60. Ургахуй цаст цагаан уул оршибай
61. Бурхан багшийн магтаал оршибай
62. Бурхан багшийн магтаал сайтар номлосон зүрхэн хэмээх оршибай
63. Балува лодон шаравын магтаал оршибай
64. Хуврагийн далай ламын магтаал оршибай
65. Майдарын магтаал Эсэрүний титэм хэмээх оршибай
66. Майдарын магтаал
67. Манзуширийг баясан үйлдэхүй магтаал үүлэн далай оршив
68. Далай ламын тууж магтаал оршив
69. Чухал адистидын үндсэн лам нарын магтаал оршибай
70. Жалцав цоржийн магтаал
71. Сухавадийн ерөөл оршибай
72. Дөрвөн хүчээр наминчлахуй үйлдвэр хүчээр оршибай
73. Ламыг холоос санахуй залбирал оршибай
74. Майдарын гэгээн төрөхүй залбирал оршибай
75. Манзуширийн залбирал оршибай
76. Чанар туурвилаас ангирсан оршибай
77. Бодь мөрийн үр оршибай
78. Майдарын залбирал оршибай зэрэг бүтээлүүдийг төвд хэлнээс тод үсэгт

орчуулсан бөгөөд дээрхи судар, шастир бүтээлүүд БНХАУ-ын газар нутаг дээр хаана, ямар газрын сан хөмрөгт хувь хүний гар дээр хадгалагдаж байгааг маш тодорхой, дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн байна.

Дээрхээс ажиглахад Зая бандида Намхайжамцын орчуулгын бүтээлийн талаар өнөө хэр бүрхэг байсан зарим асуудалд хариулт өгөхийн зэрэгцээгээр түүний орчуулгын бүтээлүүдийг цаашид нягтлан бүртгэх боломж бололцоог судлаач бүрдүүлж өгсөн байна.

ТАВДУГААР БҮЛЭГ: Зая бандидын байгуулсан Их Хүрээ

Зая бандид Намхайжамцын байгуулсан Их хүрээний тухай судалгааг Өвөр Монголын эрдэмтэн Боржигдой Оюунбилиг тусгайлан судалсны үндсэн дээр зохиогч тус Их Хүрээний байгуулагдсан цаг, шавилж сууж байсан шавь нар хийгээд тус хүрээний хөгжилтийн үе шатыг өгүүлсэн байна. Их Хүрээнээ шавилж ирсэн хүүхдүүд **нэгдүгээрт:** Дөрвөн Ойрадын ноёд язгууртнуудын хүүхдүүд, **хоёрдугаарт:** Ноёд язгууртнуудын өглөгт ирсэн банди хүүхдүүд, **гуравдугаарт:** Шавилахаар ирсэн шавь нарын олонхи нь Төвдөд эрдэм сураад ирсэн байвал нэнэ сайн, **дөрөвдүгээрт:** Монголын өөр овог, аймаг ястан үндэстний хүмүүс ч бас байжээ.

Эдгээрээс зөвхөн өргөгдөж ирсэн банди шавьнарын тоо 630-д хүрсэн байна. Их Хүрээний аж ахуйн асуудалд чухам юуны учирт өргөл барьц өргөсөн, түүнийг ямар ямар зан үйлд зарцуулсан зэргийг нарийн тоо бүхий баримттайгаар бичсэн байна. Их Хүрээ 1644-1662 оны хооронд дээд цэгтээ хүртэл хөгжиж байсан бөгөөд 1662-1689 оны хооронд буурал доройтлын шатандаа нэгэнт орсон байна. Түүхээс үзвэл Зая бандид Намхайжамцын үүсгэн байгуулсан Их Хүрээний гол түшиг тулгуур болж байсан Очирт Сэцэн тайж болоод Галдан бошигот нарын хооронд болсон дайн самууны уршгаар ихээхэн бууран доройтож нэгэнтээ мөхөхийн нь суурь тавигдсан байна. Эндээс Их Хүрээнээ шавилагчид зарим нь Төвд рүү, нөгөө хэсэг нь Ижил мөрний торгууд руу, гурав дахь хэсэг нь Галдан бошиготод дагалдан³ орсон гунигт түүхийн дүр зураг бэлхнээ харагдаж байна.

Мөн энэ бүлэгт Их Хүрээний шавь нараас зүй бусаар авирласан асуудлыг шийдвэрлүүлж өгөхийн учирт заргын бичиг үйлдэж Галдан бошиготод хэрхэн хүргүүлсэн, уг загын үнэн мөнийг бошигот шийдвэрлэж шавь нар хэрхэн заргаа авч ялалтанд хүрснийг бүрэн эхээр нь нийтэлсэн заргын бичгээс харж болно.

Зая бандид Намхайжамцын үүсгэн байгуулсан Их Хүрээг хожим шавь нар сэргээн байгуулж Хутагтын Хүрээ нэртэйгээр 1770-аад оны дунд үе болж ирэхэд Увш хаан торгуудуудыг дагуулж Зүүнгарт ирэхэд хүртэл Хутагтын Хүрээ байсаар байжээ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ: Зая бандид хийгээд Төвд, Чин Улсын харилцаа

Уг бүлэгтээ зохиогч урд өмнө судалгааны эргэлтэд харахан ороогүй БНХАУ-ын Түүхийн нэгдүгээр архивт хадгалагдаж байсан гэдэг Зая бандидаас Чин Улсад өргөсөн нэгэн хувь албан бичгийг шинээр илрүүлж судалгааны эргэлтэд оруулсан явдал нь нэн чухал байна.

³ Равжамба Зая бандид Намхайжамц судлал. УБ., 2008, 176-р тал.

Зая бандид Намхайжамц нийтдээ Төвдөд гурвантаа зорчиж эхний удаад 1616-1638 жилийн хооронд 22 жил шавилж суусан бөгөөд 1650-1661 оны хооронд хоёронтоо очсон аж. Түүний Төвдөд очсон хоёр удаагийн явдалд өргөж барьсан мөнгө, бэлэг сэлтийн тухайд “Сарны гэрэл”, “Алтан эрхи”, “V Далай ламын анмтар” зэрэг гурван бүтээлд маш тодорхой дурдсан байдгийг, Тэмдэглэл-I,II,III хэмээн тус тусад нь өгүүлсэн байна.

Мөн Зая бандид хийгээд Чин Улсын харилцааны тухайд хэсэгтээ БНХАУ-ын Түүхийн 1-р архивт Зая бандидаас V Далай ламыг залж шашин дэлгэрүүлэх тухай Дайчин Улсын Эеэр Засагч хаанд өргөсөн уйгаржин монголоор бичигдсэн нэгэн айлтгал ба манж орчуулгыг олсноо зохиогч, айлтгалын эх, сийрүүлэл, латин галиг, агуулгыг тус тус 199-203 дахь талд бүрэн гаргаад зогссонгүй “Айлтгал”-ыг хэн бичсэн, хэн хүргэж өгсөн тухайн хүмүүс болох Равжамба, Шанзудба цоржийн тухай мэдээлсэн байна. Уг “Айлтгал”-ын тухайд Оросын монголч эрдэмтэн И.Я.Златкиний үзэл баримтлалд⁴ /Далай ламын Бээжинд эзэн хааны ордонд хүрэлцэн очсон бөгөөд Зая бандид Намхайжамцын Лхаст хүрсэн явдлыг судлаач жирийн тохиолдол биш хэмээн үзсэн байдаг/ зохиогч шүүмжлэлтэй хандаж, Эеэр Засагч хаантай эв найртай байхыг хичээсэн төдийгүй Өвөр Монголын хөх хот зэрэг газруудаар явж шашны зан үйлийн болоод нутгийн аялгууны өв цуглуулж явсан болов уу, гэдэг үзлийг судлаач гаргаж тавьсан байна. Гэхдээ “Харин “Тэгээнээ эс танигдав ч цагаан сэтгэлийн үүднээс айлтгав”, “”Ер монгол хэлтэнд Зүрчидийн хаанаас ихгүй ” гэх зэргээр, Манжийн хаанд эв найртай байхыг хичээсэн аяс илүү мэдэгдэж байна. Түүгээр үл барам Зая бандид 1647 онд Бээжинд элч томилон Чин Улстай харьцаж байсан юм.”⁵ Гэсэн нь шууд утгаараа Чин Улстай эвтэй сайн харьцаж байсан гэдгийг бүрэн батлах болов уу, хэмээн санагдана. Энэ чухал асуудалд хэд хэдэн хөдөлбөргүй баримт бас ч ганц өнцгөөс бус илүү өргөн далайцтай судалж байж эцсийн хариулт, гаргалгаа гарч ирэх буй за, хэмээн мунхаглана.

Долоодугаар бүлэг: Зая бандидын хувилгаан хийгээд

Зая бандидын шүтээн хөрөг

Үнэндээ Раднаабадрагийн “Равжамба Зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршибай” бүтээлийн сүүлчийн хэсэгт Зая бандид Намхайжамцын хэрхэн хувилан өөд болсон ёсонг өгүүлсэн байдаг. Зая бандидын хувилсан тухай тэмдэглэл, Далай ламаас Зая бандидын хувилгаан үтэр өөд болохын бэлгэ болгон магтаал бичиж шавь нарт нь соёрхсон тухайд ч “Сарны гэрэл”-д байдаг. “Сарны гэрэл”, “Алтан эрхи”-д Зая бандидыг Хөх луу жил буюу 1664 онд Төвдөд хувилсан нь Зая бандидын таалал төгссөнөөс хоёр жилийн хойно болсон ажээ. Зохиогч Зая бандидын хувилгааныг Төвдөд төрснийг хэд хэдэн асуудлаар “...улс төрийн оролцоотойгоор Төвдөд илрэхийг тогтоож өгсөн.”⁶ хэмээжээ. Үнэндээ түүхийг аваад үзвэл үнэхээр тийм мэт харагдаж байгаа хэдий ч /Зая бандидын Төвдтэй онцгой харьцаатай байсан нь цаашдаа Төвдүүдэд ашигтай байсан ч /хүний хойд төрөл, хойд нас ялангуяа эрдэмтэй том ламын хойд дүрийг тодруулах явдалд өөрийн жам ёсны хувь тавилан, төөрөг байдгийг буддын шашин хийгээд түүнийг

⁴ Равжамба Зая бандид Намхайжамц судлал. УБ. 2008.,213-р тал

⁵ Равжамба Зая бандид Намхайжамц судлал. УБ. 2008.,217-р тал

⁶ Равжамба Зая бандид Намхайжамц судлал. УБ. 2008.,225-р тал

шинэтгэсэн гэгддэг Төвдийн Зонховын шашны номонд хүртэл бичиж тэмдэглэсэн бий. Иймийн учирт Зая бандидын хойд дүр чухам яагаад, заавал Төвдөөс бүр Лхас хавийн Хар хот гэдэг газар тодорсон явдал өнөө хэр тайлагдаагүй ээдрээтэй асуудал хэвээр байна.

Зохиогч Их Хүрээний доройтол, Очирт тайжийн ялагдал, Дөрвөн Ойрадын зөрчил, тэмцлийн улмаас Зая бандидын хойд дүр монгол нутагт өөдөлж тодроогүй хэмээн үзсэн нь тухайн цагт Төвд ч гэсэн тийм тайван амгалан байсан эсэхийг эргэж бодуулахад хүргэж байна. Дээрхээс харахад Төвдийн шашины бодлого, монголд дэлгэрсэн учир шалтгаан, Монголчуудын дотоод хэрэгт шууд эрээ цээргүй хутгалдсан /зарим талаас харахад хутгалдах нөхцлийг бүрэн бүрдүүлж өгсөн явдал/ Төвдийн Далай лам, Ванчин Эрдэнэ нарын зэрэг шашны томоохон зүтгэлтнүүдийн үнэн төрх, үзэл баримтлал, бодлого, санаа онооны талаар ч бас дахиж маш няхуур, нарийн ажиглалт, тандалт, судалгаа хийх нь зүйтэй мэт санагдана.

Зая бандидын шүтээн хөргийг Далай ламын зарлигаар тохой урт, гурван зуун лан мөнгөөр бүтээсэн болохыг тэмдэглэжээ. V Далай ламын дэргэд гурав хоног залагдсан үг шүтээнд зориулж “Дээд цагаан охь” хэмээх долоон бадаг ерөөлийн шүлэг айлдсаныг Раднаабатра Төвд хэлнээс орчуулсан ажээ.

Судлаач Бээжингийн хааны ордны музейн хадгаламжинд буй 34 см алтагдсан зэс хөрөг байдгийг мэдээлж, улмаар уг хөргийн тухайд нэлээд нягталж үзэхийг зорьсон бөгөөд хараахан эцсийн шийдэлд нэг мөр хүрээгүй байна.

ДҮГНЭЛТ

Мянгад Эрдэмт “Равжамба Зая бандида Намхайжамц судлал” /BIBLIOTHECA ORATICA VII., Равжамба Зая бандида Намхайжамцц судлал.,УБ.2008/ бүтээл нь Зая бандида Намхайжамцын намтар, бүтээлийн судлалд зарим талаар бүдэг бүрхэг байсан цөөнгүй асуудалд намтар, орчуулгын бүтээлүүдийн талаар, Төвдийн шашиныг Монголд дэлгэрүүлэхэд түүний гүйцэтгэсэн үүрэг, хэтийн зорилго, Зая бандидын Чин Улстай харилцаж байсан харицааны тухайд гэх зэрэгт хариулт өгсөн болохыг онцлон тэмдэглэж байна. Нөгөө талаар зарим зүйлийг гарцаагүй нягталж үзүүштэй байдал ч ажиглагдаж байна. **Нэгэн зүйл:** Заяа бандидын Дөрвөн Ойрад болон Халх долоон хошуунд Төвдийн шашиныг дэлгэрүүлэх их үйлсэд оройлон гар бие оролцохдоо V Далай ламын болоод IV Ванчин Эрдэнийн бодлогыг баримталж байсан, тэдний төлөөний хүн байсан гэх, энэ Төвдүүдийн хувьд ихээхэн чухал асуудал байсан зэргийн тухай дахин нягталж харах нь зөв зүйтэй мэт санагдана. **Нэгэн зүйл:** Зая бандида судлалын хүрээнд эрдэмтэд, судлаачдын дунд “Барс жилээс барс жил” гэдэг ойлголтын их дэлгэрсэн нь 1602-1662 оны хооронд нэгэн жарны хугацаанд Усан барс жил-Хар барс жил хоёронтоо тохиож байсан мэтээр тэмдэглэжээ. Уг нь жаранд ийн давхцал тохиох учиргүй бөгөөд үүнийг таван махбодын онолоор тайлбарлаж болох юм. **Нэгэн зүйл:** Зая бандида Намхайжамцын хөрөг шүтээний талаархи асуудлыг судалгааны хүрээнд оруулахдаа үлдэж хоцорсон байх магадтай /V Далай ламын зарлигаар бүтээсэн тохой урт, гурван зуун лан мөнгө орсон хөрөг шүтээн чухам хэдийд, хэрхэн, яаж, хэний оролцоотойгоор хаашаа үгүй болсон, хэрэв үнэхээр Ховдын нутагт үе улиран хадгалагдагдаж байгаа бол түүнийг тодорхой болгох, Бээжингийн хааны

ордны музейн хөмрөгт буй 34 см алтадсан зэс хөрөг гарцаагүй Зая бандидын хөрөг болохыг хөдөлбөргүй батлах, энэ тухайд данс, тэмдэглэл бий эсэх зэргийг / зарим асуудлыг дахин нягталж тодруулах болов уу.

НОМ ЗҮЙ

1. Батмөнх Б (2004), Зая бандида Огторгуйн далай. УБ.,
2. Дагвадорж Д (2001), Монголын бурханы шашны соён гэгээрүүлэгчид. УБ.,
3. Далай Ч (2002), Ойрад Монголын түүх (Тэргүүн боть). УБ.,
4. Дамбийпэлжид П (1998), Ойрад Монголын эртний уран зохиолын товчоо. Хайлаар.
5. Дамдинсүрэн Ц (1959), Монголын уран зохиолын дээж зуун билиг оршибай. УБ.,
6. Лувсанбалдан Х (1969), Ойрадын Зая бандида Намхайжамцын орчуулгын мэдээ. /Хэл зохиол судлал/. УБ.,
7. Мянгад Эрдэмт (2008). “Равжамба Зая бандида Намхайжамц судлал” /Bibliotheca oiratica VII/, УБ.,
8. Ната (1991), Алтан эрхи. /Чойжи харьцуулж тайлбарласан/. хөх хот.
9. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд, (2001). I дэвтэр. /хэвлэлд бэлтгэсэн На.Сүхбаатар/. УБ.,
10. Раднаабдрагийн “Равжамба Зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршибай”, (1997), Хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо, Ц.Хосжаргал. УБ.,
11. Хишигтогтох Ч (1998), “Зая бандида Намхайжамцын тууж (Сарны гэрэл)-ийн судлал”, Хөх хот.
12. Хишигтогтох Ч (2002), Монголын эртний уран зохиолын шинэ судлал. УБ.,
13. Хүрэлбаатар Л (1994), Монгол орчуулгын товчоон. УБ.,
14. Цэрэнсодном Д (1982), Намхайжамцын шүлгийн тухай. /Дамдинсүрэн.Ц. Цэнд.Д. Монгол уран зохиолын тойм./ Хөх хот.
15. Цэрэнсодном Д (1996), Бурханы шашины уран зохиол. /Тэргүүн дэвтэр/. УБ.,

SUMMARY

The studies on the biography and works of Zaya Pandita Namkhajamts have attracted the national and international scholars' attention for ages. Researchers penetrate into his works through his biography named “Ravjaa Zaya Pandita novel Lunar light” by Radnaabadra. The practical importance of “Ravjaa Zaya Pandita Namkhajamts Study” is that it registered all materials and sources related to his biographical study in detail. On the other hand, on his return to Oirat as a representative of Dalai Lama V and Banchin Erdene IV: “... we need to find an obedient and diligent person who follows our command to be a representative to Mongolia. Zaya Pandita was the right person on the side of Tibet”⁷. It seems to be a hasty conclusion. It is so confusing that Zaya Pandita Namkhajamts returned to Oirat as a representative of Tibet.

⁷ Равжамба Зая бандид Намхайжамц судлал., УБ., 2008, 49-р тал.